



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/20 АЯА-2018/20/СТА-7ЦЗ Мандалговь хот

Г

Т

Төлбөр барагдуулах тухай

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэлтэй төрийн албан хаагчид **810,000.00** /найман зуун арван мянган/ төгрөгийн урамшуулалт олгосон зөрчил илэрлээ.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төловлюж зарцуулах/, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.4-т /Сахилгын шийтгэл ногдуулнаас хойши нэг жил онгорвол сахилгын шийтгэлгүйд тооцно/. Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын 1.1-д /2017 оны төсвийн жислд төрийн ондор албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт олгох/, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд; /Улсын Их Хурлын 2017 оны 67-р тогтоолын дагуу 2017 онд төрийн ондор албан тушаалтан, шүүгч прокуророос бусад төрийн албан хаагчид 300000 төгрөгний урамшуулалт олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байдва албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулалт олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захирагч нарт даалгав/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад шээрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг аришгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал/ гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Урамшуулалт олгосон 810,000.00 /найман зуун арван мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар /туслах багши Б.Нямдэлгэр, багши Б.Шатар, багши Б.Будням/ нөхөн төлүүлж 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор тус тус төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Б.Цэцэгжаргал, нягтлан бодогч О.Ууганбаатар нарт хариуцуулав.


ТОГТООСОН¹:

АУДИТОР  Б.ГАНТУЯА

4817144213
ЗЮА0039 0033475

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ  Б.ИЭЦЭГЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ  О.УУГАНБААТАР

2540002

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж засны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулхаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.